

**ОЛОН УЛСЫН УЛААНБААТАРЫН
ИХ СУРГУУЛЬ**

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 он 12 сар 28 өдөр

Дугаар А/124

Улаанбаатар хот

“Олон улсын Улаанбаатарын их сургуулийн
санхүүжилттэй судалгааны төслийг хэрэгжүүлэх журам”-ыг батлах тухай

“Олон Улсын Улаанбаатарын Их Сургуулийн дүрэм”-ийн 3.13.6 дугаар заалт,
“ОУУБИС-ийн 2020-2025 оны стратеги төлөвлөгөө”, “Олон Улсын Улаанбаатар Их
Сургуулийн эрдэм шинжилгээ, багш нарын хөгжлийн хөтөлбөр”, Захиргааны зөвлөлийн
2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ
нь:


1. “Олон Улсын Улаанбаатарын Их Сургуулийн санхүүжилттэй судалгааны төслийг
хэрэгжүүлэх журам”-ыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. “Олон Улсын Улаанбаатарын Их Сургуулийн санхүүжилттэй судалгааны төслийг
хэрэгжүүлэх журам”-ыг эрдэм шинжилгээ, инновацийн үйл ажиллагаанд мөрдөж
ажиллахыг бүтцийн нэгжүүдийн удирдлагууд, нийт багш нарт даалгасугай.
3. Тус журмыг хэрэгжүүлэх ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангаж
ажиллахыг Сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал (А.Хандмаа)-д үүрэг
болгосугай.
4. Тус журамтай холбоотой гарах санхүүгийн зардлыг ОУУБИС-ийн захирлын 2021
оны 03 сарын 31-ний А/30 тоот тушаалын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан
“ОУУБИС-ийн багш, ажилчдын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх,
санхүүжүүлэх журам”-ыг үндэс болгон хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн хэлтсийн
дарга (Э.Чулуунцэцэг)-т үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



КАН ЮУ ЁЛЬ

ОУУБИС-ийн ерөнхий захирлын
2022 оны 12 сарын 28 өдрийн
А/124 дугаар тушаалын хавсралт



ОЛОН УЛСЫН УЛААНБААТАРЫН ИХ СУРГУУЛИЙН САНХҮҮЖИЛТТЭЙ СУДАЛГААНЫ ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. ОУУБИС-ийн бүрэлдэхүүн сургууль, судалгааны хүрээлэн, төвийн багш, судлаачдын шинэ мэдлэг бүтээх, нээлт хийх, дэвшилтэт технологи бүтээх, түгээн дэлгэрүүлэх зэрэг эрдэм шинжилгээний ажлыг дэмжих; тэдний бүтээлийн чанар, судалгааны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх; сургуулийн эрдэм шинжилгээний гадаад дотоодын хамтын ажиллагааг сайжруулахад чиглэсэн судалгааны төсөл хэрэгжүүлэх зарчмыг тогтоох, түүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.
- 1.2. Төсөл дэвшүүлэгчийн тодорхой өртөг, зардлын тооцоо нь тухайн төслийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд төслийн санхүүжилтийн хэмжээг тогтоох үндэс болно.
- 1.3. Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь ОУУБИС-ийн ерөнхий захирлын 2021 оны 03 сарын 31-ний А/30 тоот тушаалын 4-р хавсралтаар батлагдсан “ОУУБИС-ийн багш, ажилчдын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, санхүүжүүлэх журам”-аар зөвшөөрөгдсөн зардлын бүрдэлд нийцсэн байх;
- 1.4. ОУУБИС дараах судалгааны төсөл, тэтгэлгийг санхүүжүүлнэ. Үүнд:
 - 1.4.1. Суурь судалгааны төсөл
 - 1.4.2. Профессор, дэд профессор, доктор багш нарт олгох судалгааны төсөл
 - 1.4.3. Захиалгат төсөл, судалгаа
 - 1.4.4. Залуу судлаачдын багийн тэтгэлэг
 - 1.4.5. Инновацийн төсөл
 - 1.4.6. Өртөг хуваалцах хамтарсан төсөл
 - 1.4.7. Ном, сурах бичиг, гарын авлага хэвлүүлэх тэтгэлэг

ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү журамд хэрэглэгдэж байгаа нэр томъёог дараах утгаар ойлгоно.

- 2.1. “Суурь судалгааны төсөл” гэж ОУУБИС-д профессор, дэд профессор, ахлах багшийн зэрэглэлд ажиллаж байгаа докторын зэрэгтэй үндсэн багшийн судалгааны ажлыг дэмжих зорилготой, хүн, нийгэм, урлаг, хүрээлэн буй орчны хөгжлийн үндсэн зүй тогтлын талаар шинэ мэдлэг, мэдээлэл бий болгох судалгааны ажлын эцсийн үр дүнг Journal Citation Report (JCR)-ын импакт фактортай олон улсын мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлэх, нэг сэдэвт бүтээл хэвлүүлэх зорилго бүхий судалгааны ажлын төслийг хэлнэ.

- 2.2. “Профессор, дэд профессорын судалгааны төсөл” гэж ОУУБИС-д профессор, дэд профессорт олгох судалгааны ажлын үр дүнд олон улсын мэргэжлийн түвшинд хянагддаг Web of Science-ийн SCI (Sciences Citation Index), SSCI (Social Sciences Citation Index), AHCI (Art & Humanities Citation Index) болон Scopus-т бүртгэлтэй сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх, нэг сэдэвт зохиол, мэргэжлийн ном, толь бичиг хэвлүүлэх, патент, лиценз авах, олон улсын хуралд оролцох ОУУБИС-ийн профессор, дэд профессорын зэрэглэлд ажиллаж байгаа, үндсэн орон тооны багш болон эрдэм шинжилгээний ажилтны судалгааны ажлын санхүүжилтийг хэлнэ.
- 2.3. “Захиалгат төсөл, судалгаа” гэж ОУУБИС-ийн чанарын болон хөгжлийн бодлого, эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэл, бүрэлдэхүүн сургуулийн сургалт, үйл ажиллагааны тулгамдсан асуудлыг судалж, шийдвэрлэхэд чиглэсэн төсөл, судалгааг хэлнэ.
- 2.4. “Залуу судлаачдын багийн тэтгэлэг” гэж 45 хүртэлх насны 3-аас доошгүй залуу судлаачдаас бүрдсэн багийн захиалсан судалгааны ажлын санхүүжилтийг хэлнэ.
- 2.5. “Инновацийн төсөл” гэж патентын мэдүүлэг, патентад үндэслэн лицензийн гэрээ, гарааны компани байгуулах, эсвэл оюуны эрхээр хамгаалагдсан инновацийн бүтээгдэхүүн, үйл ажиллагааг сургалтад нэвтрүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх, эргэн төлөгдөх нөхцөлтэй төслийг хэлнэ.
- 2.6. “Өртөг хуваалцах хамтарсан төсөл” гэж нэг талаас ОУУБИС, нөгөө талаас олон улсын байгууллага, гадаад, дотоодын судалгааны сан, их дээд сургууль, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран судалгааны санхүүжилтийн зардлыг дундаасаа босгож хэрэгжүүлэх хоёр болон олон талт төслийг хэлнэ.
- 2.7. “Ном, сурах бичиг, гарын авлага хэвлүүлэх тэтгэлэг” гэж ОУУБИС-ийн үндсэн багш, судлаачдын тодорхой гэрээ, төсөл хөтөлбөрийн хүрээнд бий болоогүй ном, сурах бичиг, гарын авлагыг хэвлүүлэх үйл ажиллагаанд зарцуулах, эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжилтийг хэлнэ.

ГУРАВ. ТӨСӨЛД ТАВИГДАХ НИЙТЛЭГ ШААРДЛАГА

- 3.1. Төслийн удирдагч нь доктор зэрэгтэй, ОУУБИС-ийн үндсэн орон тооны багш байна.
- 3.2. Төслийг гүйцэтгэгч нь дор дурдсан этгээд байна.
 - 3.2.1. ОУУБИС-ийн судалгааны хүрээлэн, төв;
 - 3.2.2. ОУУБИС-ийн бүрэлдэхүүн сургууль, тэнхим;
 - 3.2.3. ОУУБИС-ийн судлаачдын баг (Гадны байгууллагаас цөөн тооны гишүүн авсан байж болно);
 - 3.2.4. ОУУБИС-ийн үндсэн багш, судлаач, оюутан
- 3.3. Судалгааны төсөл нь ОУУБИС-ийн тэргүүлэх болон хэрэглээний судалгааны чиглэлээр шинэ мэдлэг, нээлт, дэвшилтэт технологийг бүтээх, хуримтлуулах, дэлгэрүүлэх зорилготой, оюуны өмчийн болон ёс зүйн зөрчилгүй байна.
- 3.4. Төсөл хэрэгжүүлэх дээд хугацаа 2 жил байна.

- 3.5. Аливаа төслийг тухайн гэрээнд заасан хугацаанаас хэтрүүлэхгүй хийж гүйцэтгэнэ. Төсөл гэрээнд заасан хугацаанд хэрэгжих боломжгүй болсон тохиолдолд захиалагч гэрээг сунгах хүсэлтээ сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн даргаар дамжуулан, сургуулийн Захиргааны зөвлөлд хүргүүлнэ. Захиалагчаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл төсөл хэрэгжүүлэх хугацааг тодорхой хугацаагаар сунгаж болно.
- 3.6. Олон улсын мэргэжлийн түвшинд хянагддаг Web of Science-ийн SCI (Sciences Citation Index), SSCI (Social Sciences Citation Index), AHCI (Art & Humanities Citation Index) болон Scopus-т бүртгэлтэй сэтгүүлд өгүүлэл, нэг сэдэвт зохиол, мэргэжлийн ном, толь бичиг хэвлүүлэх тохиолдолд ОУУБИС-ийн албан ёсны нэр (International University of Ulaanbaatar)-ийн товчлолыг англиар "IUU" хэмээн тэмдэглэнэ.
- 3.7. Судалгааны судалгаа, төсөл, тэтгэлгийг олон улсын стандартын дагуу дугаарлаж ангилна. Сургуулийн нэр, төсөл хэрэгжих он, төслийн ангилал (латин үсгээр), дугаар (тоогоор) гэсэн дарааллаар (IUU2022A001) тэмдэглэнэ.
- 3.8. Төслийн ангиллыг Суурь судалгааны төсөл (A), Профессор, дэд профессорын судалгааны тэтгэлэг (B), Захиалгат төсөл (C), Залуу судлаачдын багийн тэтгэлэг (D), Инновацийн төсөл (E), Өртөг хуваалцах хамтарсан төсөл (F), Ном, сурах бичиг, гарын авлага хэвлүүлэх тэтгэлэг (G) хэмээн латин үсгээр тэмдэглэнэ.
- 3.9. Төслийн хэрэгжилтийн явцад бий болсон оюуны өмчийг өмчлөх, эзэмших асуудлыг МУ-ын Инновацийн тухай хуулийн 27.1-д заасны дагуу шийдвэрлэнэ.
- 3.10. Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаа дараах үе шаттай явагдана.
- 3.10.1. Төслийг захиалах, нээлттэй зарлах, дэвшүүлэх;
 - 3.10.2. Төслийг боловсруулах, мэдүүлэх;
 - 3.10.3. Төслийг сонгон шалгаруулах;
 - 3.10.4. Гэрээ байгуулж баталгаажуулах;
 - 3.10.5. Хэрэгжилтийн явцад хяналт тавих;
 - 3.10.6. Хэрэгжилтийн явц, гүйцэтгэл, үр дүнг мэдээлэх, тайлагнах, баталгаажуулах;
 - 3.10.7. Төслийн үр дүнг хүлээлгэн өгөх, санхүүгийн тооцоо хийж дуусгах;
- 3.11. Төсөл хэрэгжүүлэхэд дор дурдсан үндсэн зарчмыг баримтална.
- 3.11.1. Үр ашигтай байх;
 - 3.11.2. Тэгш өрсөлдөх боломжтой байх;
 - 3.11.3. Ил, тод байх;
 - 3.11.4. Шинжлэх ухаан, технологийн болон сургуулийн судалгааны тэргүүлэх чиглэлд хамаарах, төслийг эхний ээлжинд сонгон хэрэгжүүлнэ.
- 3.12. Тус сургууль нь төрийн болон орон нутгийн захиргаа, агентлаг, аж ахуйн нэгж, иргэнтэй хамтарсан төслийг захиалж болно.
- 3.13. Судалгааны төслийн санал, холбогдох материалыг сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга хүлээн авч, уг төслийг хэрэгжих шаардлагатай эсэхийг сургуулийн Захиргааны зөвлөлийн хурлаар оруулж шийднэ.

- 3.14. Судалгааны төсөл, тэтгэлгийн санхүүжилтийн хэмжээ болон олгох асуудлыг ОУУБИС-ийн Захиргааны зөвлөлөөс тогтооно.
- 3.15. Судалгааны ажлын төсөл хэрэгжүүлэх баг нь тухайн нэгжийн ажлын өрөө, анги танхим; судалгааны лаборатори, компьютер болон бусад техникийг ашиглах эрхтэй.
- 3.16. Судалгааны төслийн санхүүжилтийг тэтгэлгийн санхүүжилт хэлбэрээр олгож болно.
- 3.17. Төслийн зарцуулалтын тайлан, холбогдох санхүүгийн баримтыг сургуулийн Санхүүгийн хэлтэст хүлээлгэн өгнө.
- 3.18. Төслийн тайланг сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн даргаар дамжуулан, Захиргааны зөвлөлд тайлагнана.

ДӨРӨВ. ТӨСӨЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

4.1. Суурь судалгааны төсөлд тавигдах шаардлага:

- 4.1.1. Суурь судалгааны төслийг судлаачдын баг, судлаач өөрсдөө дэвшүүлнэ.
- 4.1.2. Суурь судалгааны төсөлд дараах шаардлага тавигдана. Үүнд:
 - 4.1.2.1. ОУУБИС-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлийг хөгжүүлэх зорилготой байх;
 - 4.1.2.2. Төслийн шинэлэг талыг нотолсон байх;
 - 4.1.2.3. Төслийн үр дүнд Journal Citation Reports (JCR)-ын импакт фактор бүхий олон улсын мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл, эсвэл олон улсын хэвлэлийн компанид нэг сэдэвт бүтээл хэвлүүлнэ. Мөн ОУУБИС-ийн нэр дээр мэдүүлсэн оюуны өмчийн эрхийн хамгаалалтыг үр дүнд тооцно.
- 4.1.3. Судалгааны ажлын санхүүжилтийг дараах зардалд зарцуулна. Үүнд:
 - 4.1.3.1. Олон улсын мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх;
 - 4.1.3.2. Нэг сэдэвт бүтээл хэвлүүлэх;
 - 4.1.3.3. Эрдмийн зэрэг горилсон судалгааны ажлыг нэг сэдэвт бүтээл болгон хэвлүүлэх тохиолдолд тухайн бүтээлийн агуулгын 70 хүртэлх хувь нь шинэчлэгдсэн байна.
 - 4.1.3.4. Судалгаа шинжилгээ, сорилт туршилтад шаардагдах багаж төхөөрөмж, түүний хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор бүрдэл хэсэг, эд анги, материал, мэргэжлийн ном, сэтгүүл, өгүүлэл, программ худалдан авах;
 - 4.1.3.5. Оюутанд ажлын хөлс, тэтгэлэг олгох (Судлаачдын залгамж холбоог бэхжүүлэх үүдээс судалгааны ажилд туслах магистрант, докторант оюутныг удаан хугацаанд тогтвортой ажиллуулахыг илүү дэмжинэ);
 - 4.1.3.6. Лабораторийн судалгаанд зарцуулах;
 - 4.1.3.7. Хээрийн судалгаанд зарцуулах;
 - 4.1.3.8. Олон улсын хуралд оролцох, семинар зохион байгуулах, оролцох;
- 4.1.4. Төслийн багийн бүрэлдэхүүнд ОУУБИС-ийн профессор багш болон магистрант, докторантын зэрэгцээ бусад байгууллагын эрдэмтэн, судлаачийг оруулж болно.
- 4.1.5. Судалгааны ажлын санхүүжилтийг үндсэн байгшийн цалин хөлсөнд зарцуулахгүй. ОУУБИС-аас гаднах байгууллагын эрдэмтэн, судлаачийг оруулж ажилласан

тохиолдолд төслийн санхүүгийн 15 хувиас хэтрэхгүй хэмжээг түүний цалин хөлсөнд зарцуулж болно.

4.1.6. Суурь судалгааны төслийн санхүүжилт авах саналаа Загвар 1-ийн дагуу бичиж сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн даргад хүргэнэ.

4.2. Профессор, дэд профессор, доктор багш нарт олгох судалгааны төсөлд тавигдах шаардлага

4.2.1. ОУУБИС-д профессорын болон дэд профессор, эсвэл ахлах багшийн зэрэглэлд ажиллаж байгаа доктор зэрэг (докторын зэргээ хамгаалаад 5 жил болсон)-тэй үндсэн багш энэхүү судалгааны төслийг өөрсдөө дэвшүүлнэ.

4.2.2. Профессор, дэд профессор, доктор багшийн судалгааны төсөлд дараах шаардлага тавигдана.

4.2.2.1. Судалгааны ажлын үр дүнд олон улсын мэргэжлийн түвшинд хянагддаг Web of Science-ийн SCI (Sciences Citation Index), SSCI (Social Sciences Citation Index), ANCI (Art & Humanities Citation Index) болон Scopus-т бүртгэлтэй сэтгүүлд өгүүлэл, эсвэл нэг сэдэвт бүтээл хэвлүүлэх

4.2.2.2. Судалгааны ажлын үр дүнгээ 1 жилийн хугацаагаар тооцож, тодорхой тусгах

4.2.3. Судалгааны ажлын санхүүжилтийг дараах зардалд зарцуулна. Үүнд:

4.2.3.1. Сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх;

4.2.3.2. Нэг сэдэвт зохиол, мэргэжлийн ном, толь бичиг хэвлүүлэх;

4.2.3.3. Багаж төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор бүрдэл хэсэг, эд анги, материал; мэргэжлийн ном, сэтгүүл, өгүүлэл, программ худалдан авах;

4.2.3.4. Лабораторийн болон хээрийн судалгаа хийх;

4.2.3.5. Хээрийн судалгаанд зарцуулах;

4.2.3.6. Олон улсын судалгааны төв, лабораторид ажиллах, туршилт явуулах;

4.2.3.7. Зочин судлаач урих, хамтарсан судалгаа хийх;

4.2.3.8. Патент, лиценз авах;

4.2.3.9. Гадаад томилолт (тухайн судалгааны сэдэвтэй шууд холбоотой байх);

4.2.3.10. Олон улсын хуралд оролцож илтгэл хэлэлцүүлэх

4.2.4. Судалгааны ажлын санхүүжилтийг үндсэн байгшийн цалин хөлсөнд зарцуулахгүй. ОУУБИС-аас гаднах байгууллагын эрдэмтэн, судлаачийг оруулж ажилласан тохиолдолд төслийн санхүүгийн 15 хувиас хэтрэхгүй хэмжээг түүний цалин хөлсөнд зарцуулж болно.

4.2.5. Тэнхим болон профессорын багаар хамтран хэрэгжүүлж буй судалгааны ажилд профессор, дэд профессор, докторууд хамтран судалгааны төсөлд санал өгч болно.

4.2.6. Судалгааны тэтгэлгийн саналаа Загвар 2-ын дагуу бичиж, сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн даргад хүргэнэ.

4.3. Захиалгат судалгаа, төсөлд тавигдах шаардлага

- 4.3.1. ОУУБИС-ийн чанарын болон хөгжлийн бодлого, эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэл, бүрэлдэхүүн сургуулийн сургалт, үйл ажиллагааны тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн судалгаа, төслийг сургуулиас зарласны дагуу хэрэгжүүлнэ.
- 4.3.2. Захиалгат төсөлд дараах шаардлага тавигдана. Үүнд:
 - 4.3.2.1. ОУУБИС болон бүрэлдэхүүн сургуулиас дэвшүүлсэн тулгамдсан асуудлыг хэрхэн шийдэж байгааг нотлох;
 - 4.3.2.2. Захиалгат төсөлд оролцох багийн гишүүдийг сонгохдоо 2 ба түүнээс дээш мэргэжлийн тэнхимийн судлаачдыг хамруулсан байх;
 - 4.3.2.3. ОУУБИС-ийн Захиргааны зөвлөлийн шийдвэр дээр үндэслэн санхүүжилтийг олгох;
- 4.3.3. Судалгааны ажлын санхүүжилтийг дараах зардалд зарцуулна. Үүнд:
 - 4.3.3.1. Судалгаанд зарцуулах;
 - 4.3.3.2. Гадаад хэл дээрх ном, сурах бичиг орчуулах;
 - 4.3.3.3. Сургалт зохион байгуулах, сургалт семинарт оролцох;
 - 4.3.3.4. Багаж төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилготой бүрдэл хэсэг, эд анги, материал, мэргэжлийн ном сэтгүүл, программ худалдан авах
- 4.3.4. Захиалгат төслийн санхүүжилт авах саналаа Загвар 1-ийн дагуу бичнэ.

4.4. Залуу судлаачийн багийн тэтгэлэгт тавигдах шаардлага

- 4.4.1. ОУУБИС-ийн залуу судлаачдад эрдэм шинжилгээ судалгааны ажил хийж, шинэлэг бүтээлч санал санаачилга дэвшүүлэн, инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд нэвтрүүлэх үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих зорилготой энэхүү тэтгэлгийг судлаачид өөрсдөө дэвшүүлнэ.
- 4.4.2. Залуу судлаачдын багийн тэтгэлэгт дараах шаардлага тавигдана.
 - 4.4.2.1. Тэтгэлгийг 45 нас хүртэлх, 3-аас цөөнгүй тус сургуулийн үндсэн багш, судлаачдаас бүрдсэн багт олгоно. Ялгаатай шинжлэх ухааны салбараас баг бүрдүүлсэн бол давуу тал болно. Сургууль, бүрэлдэхүүн сургуулийн судалгааны тэргүүлэх чиглэлтэй холбоотой судалгааг онцгойлон дэмжинэ.
 - 4.4.2.2. Багийн ахлагч нь докторын зэрэгтэй байна. Бусад гишүүд нь докторын зэргээ хамгаалаагүй байж болно.
 - 4.4.2.3. Залуу судлаачдын баг дээр дурдсанчлан төслийн саналыг өөрсдөө дэвшүүлэх бөгөөд хүлээгдэж буй үр дүнгээ дээд тал нь 1 жилийн хугацаагаар тооцож, тодорхой тусгах шаардлагатай.
- 4.4.3. Тэтгэлгийн санхүүжилтийг дараах хэлбэрээр зарцуулна.
 - 4.4.3.1. Олон улсын мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл нийтлүүлэх;
 - 4.4.3.2. Багаж, төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор бүрдэл хэсэг, эд анги, материал, хүчин чадлыг нэмэгдүүлэх үүднээс программ худалдаж авах;

4.4.3.3. Оюутанд ажлын хөлс, тэтгэлэг олгох (Судлаачдын залгамж холбоог бэхжүүлэх үүдээс судалгааны ажилд туслах оюутныг удаан хугацаанд тогтвортой ажиллуулахыг илүү дэмжинэ);

4.4.3.4. Хээрийн судалгааны зарцуулалт;

4.4.4. Санхүүжилтийг олгохдоо салбар дундын шинж чанар, судалгааны нээлттэй, доктор, докторын дараах судалгааны ажлаа үр дүнд хүргэх баталгаа; багийн гишүүдийн судалгааны ажлын туршлага, судалгааны ажлын үр дүнгээр импакт фактор (SCI8 SNIP)- той сэтгүүл, мөн олон улсын SSCI, ANCI индекстэй сэтгүүлд хэвлүүлэх, оюуны өмч бий болох боломж, хамтарсан судалгаа, семинариар дамжуулан өөр шинжлэх ухаан, технологийн салбарын залуу эрдэмтэд, оюутны хоорондын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх, цаашид цогц судалгааг тогтмол хийх соёлыг төлөвшүүлэх багийг хэрхэн бүрдүүлсэн зэргийг харгалзан олгоно.

4.4.5. Залуу судлаачдын багт олгох тэтгэлгийг жил бүр зарласан хугацаанд Загвар 3-ыг ашиглан бичиж, хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүлээлгэн өгнө.

4.5. Инновацийн төсөлд тавигдах шаардлага

4.5.1. ОУУБИС-ийн үндсэн орон тооны профессор, дэд профессор, докторын зэрэгтэй багш нар сургуулийн Захиргааны зөвлөлийн дэмжлэг авсны үндсэн дээр энэхүү төслийг хэрэгжүүлнэ.

4.5.2. Инновацийн төсөлд дараах шаардлагын аль нэгийг биелүүлнэ.

4.5.2.1. Технологид суурилсан төслийн хувьд төслийн удирдагч нь батлагдсан оюуны өмчийн зохиогч байх, эсвэл тухайн оюуны өмчийг ОУУБИС эзэмшдэг байх;

4.5.2.2. Техник, эдийн засаг, нийгмийн болон шинжлэх ухааны ач холбогдол, үр ашгийн тооцоог хийсэн байх;

4.5.2.3. Нийгмийн инновацийн төслийн хувьд төслийн багийн гишүүдийн сүүлийн таван жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн бүтээлийн жагсаалт ба төслийн үр дүнг чухалчилна.

4.5.2.4. Бүтээгдэхүүн, үйлчилгээний анхдагч загварыг гаргаж, технологийн туршилт, зүгшрүүлэлт хийх талаарх мэдээллийг боловсруулсан байх;

4.5.2.5. Зах зээл дээрх ижил төстэй бүтээгдэхүүн, технологи, үйлчилгээтэй харьцуулсан судалгаа хийсэн байх;

4.5.2.6. Инновацийн төслийг хэрэгжүүлэхэд “МУ-ын Инновацийн тухай хууль”, “ОУУБИС-ийн инноваци, эрдэм шинжилгээний ажлын талаар баримтлах бодлого”-д нийцүүлэн, хамтрагч байгууллагаас дэмжлэг авах, хамтран ажиллах зарчмыг гэрээнд тодорхойлсон байх;

4.5.2.7. Төслийн хэрэгжүүлэхэд шаардлагатай шинжлэх ухааны салбарын эрдэмтэн, судлаачид, ахисан түвшний оюутнуудын хамтын оролцоо; лаборатори, багаж, тоног төхөөрөмж, туршлагын баазыг бүрдүүлсэн байна.

4.5.3. Инновацийн төслийн санхүүжилтийг дараах зардалд зарцуулна. Үүнд:

4.5.3.1. Патент, лиценз мэдүүлэхтэй холбоотой зардал;

- 4.5.3.2. Шаардлагатай тоног, төхөөрөмж, программ хангамж худалдан авах;
- 4.5.4. Инновацийн төсөл нь эргэн төлөгдөх нөхцөлтэй байх бөгөөд эргэн төлөгдөх мөнгөн дүнг гэрээгээр зохицуулна.
- 4.5.5. Төсөл хэрэгжүүлэгч нь хагас жил тутамд нэг удаа төслийн явц болон хэрэгжилтийн хүрээнд төслийн хамтрагч талуудтай танилцуулга уулзалт, хурал, зөвлөгөөнийг зохион байгуулсан байна.
- 4.5.6. Инновацийн төслийн санхүүжилт авах саналаа Загвар 1-ийн дагуу бичиж, сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн даргад хүргэнэ.

4.6. Өртөг хуваалцах хамтарсан төсөлд тавигдах шаардлага

- 4.6.1. Өртөг хуваалцах хамтарсан төслийн саналыг ОУУБИС-ийн үндсэн орон тооны профессор, дэд профессор, багш нар гаргах эрхтэй.
- 4.6.2. Өртөг хуваалцах хамтарсан төслийн саналд дараах зүйлийг тусгасан байна. Үүнд:
 - 4.6.2.1. Санхүүжүүлэгч байгууллага, судалгааны сан, гадаадын их сургууль, аж үйлдвэр, компани, төрийн бус байгууллагын хамтарсан судалгаа хийх сонирхлоо илэрхийлсэн хүсэлт;
 - 4.6.2.2. Санхүүжүүлэгч байгууллагаас төслийн санал хүлээн авах тухай зар;
 - 4.6.2.3. Санхүүжүүлэгч байгууллага, судалгааны сан, гадаадын их сургууль, үйлдвэр, аж ахуйн нэгж, компани, төрийн бус байгууллагад өгөх өртөг хуваалцах санхүүжилтийн төсөв;
 - 4.6.2.4. Төсөлд оролцох багийн гишүүдийн туршлага, олон улсын бүтээлийн жагсаалт
- 4.6.3. Өртөг хуваалцах хамтарсан төсөлд ОУУБИС-аас 30 хүртэлх хувийн санхүүжүүлтийг гаргана. Хамтарсан төсвийн ортог хуваалцахад дэмжлэг өгөх саналд доорх зардлыг оруулна. Үүнд:
 - 4.6.3.1. Гадаад дотоод томилолтын зардал;
 - 4.6.3.2. Гадаад профессорын Монгол улсад нэг долоо хоног ба түүнээс доош хугацааны дотоод зардал;
 - 4.6.3.3. Багаж төхөөрөмж, түүний суурилуулалтын зардал;
 - 4.6.3.4. Дундын багаж, төхөөрөмж ашигласан зардал;
 - 4.6.3.5. Гадны байгууллагын лабораториор гүйцэтгүүлэх урьдчилсан шинжилгээний төлбөр;
 - 4.6.3.6. Гадаад, дотоодын мэргэжлийн байгууллага, яам, агентлагаас авах зөвшөөрлийн төлбөр;
 - 4.6.3.7. Бичиг хэргийн зардал;
- 4.6.4. Өртөг хуваалцах төслийн гэрээг ОУУБИС-ийн ерөнхий захирал, төслийг хэрэгжүүлэгч профессор, дэд профессор, доктор болон өртөг хуваалцагч талтай хийнэ.
- 4.6.5. Өртөг хуваалцах хамтарсан төслийн санхүүжилт авах саналаа Загвар 4-ийн дагуу бичнэ.

4.7. Ном, сурах бичиг, гарын авлага хэвлүүлэх тэтгэлэгт тавигдах шаардлага

- 4.7.1. Ном, сурах бичиг, гарын авлага хэвлүүлэх тэтгэлгийг тус сургуульд 5-аас дээш жил тогтвортой ажилласан үндсэн багш, судлаачдад олгоно.
- 4.7.2. Хэвлүүлэх ном, сурах бичиг, гарын авлагыг бүрэлдэхүүн сургуулийн профессорын баг, эсвэл сургуулийн Захиргааны зөвлөлийн хурлаар оруулж, хэвлүүлэх зөвшөөрөл авсан тохиолдолд зохиогч нь энэхүү тэтгэлэгт хамрагдах хүсэлтээ өгнө.
- 4.7.3. Тэтгэлэгт хамруулж хэвлүүлэх ном, сурах бичиг, гарын авлага нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- 4.7.3.1. Сурах бичиг, гарын авлага нь боловсрол эзэмших тэгш байдлыг хангасан, хөтөлбөрийн онцлогийг тусгасан байх;
 - 4.7.3.2. Сурах бичиг нь боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр дэх хичээлийн агуулгад нийцсэн байх;
 - 4.7.3.3. Ном, сурах бичиг, гарын авлагад олон улсын болон Монгол улсын индекс (ISBN)-ийг заавал авсан байх;
 - 4.7.3.4. Ном, сурах бичиг, гарын авлага нь зохиогчийн эрхийг зөрчөөгүй байх;
 - 4.7.3.5. Суралцагчид уг сурах бичиг, ном, гарын авлагыг бие даан судалж, мэдлэг, чадварыг эзэмших, практикт хэрэглэх боломжтой байх;
 - 4.7.3.6. Хэл найруулга, зөв бичгийн дүрмийн хувьд алдаагүй, зөв оновчтой, товч тодорхой, энгийн ойлгомжтой, эмх цэгцтэй байх;
- 4.7.4. Энэхүү тэтгэлгийг дараах зүйлд зарцуулна. Бусад зүйлд зарцуулахыг хориглоно. Үүнд:
- 4.7.4.1. Олон улсын болон Монгол улсын индекс (ISBN)-ийг авах төлбөр;
 - 4.7.4.2. Зохиогчийн эрх авах татвар;
 - 4.7.4.3. Хэвлэлийн зардал;
- 4.7.5. Ном, сурах бичиг, гарын авлага хэвлүүлэх тэтгэлэгт 1 саяас 3 сая хүртэлх төгрөгийг 1 хувийн хүүтэй олгоно.
- 4.7.6. Тэтгэлгийг эргэн төлөгдөх хугацаа 10 сар байна.
- 4.7.7. Тэтгэлгийн буцаан төлөлтийг графикийн дагуу Санхүүгийн хэлтсээс цалингаас шууд суутгана.
- 4.7.8. Энэхүү тэтгэлгийг жил бүр зарласан хугацаанд Загвар 5-ыг ашиглан бичиж, эрдэмтэн нарийн бичгийн даргад хүргэнэ.
- 4.7.9. Захиргааны зөвлөлөөс хэвлүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд Захиргаа албаны дарга болон Санхүүгийн хэлтсийн даргатай буцаан төлөгдөх байдлын гуравласан гэрээ хийж, гэрээний хугацаанд зээлийг эргүүлэн төлнө.

ТАВ. ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАХ

- 5.1. ОУУБИС-аас санхүүжих судалгааны ажлын төсөл, тэтгэлгийн саналыг тэнхим болон бүрэлдэхүүн сургуулийн багш нарын хурлаар хэлэлцэн, жил бүрийн 1 дүгээр сарын 30-ны дотор эрдэмтэн нарийн бичгийн даргад ирүүлнэ.

- 5.2. Судалгааны ажлын төслийг нээлттэй зарлаж, сонгон шалгаруулах ба гэрээний үндсэн дээр санхүүжүүлж, хэрэгжүүлнэ.
- 5.3. Сургуулийн захиалгат төсөл, судалгааг тухайн үеийн хэрэгцээ шаардлагаас үүдэн, хугацаа харгалзахгүй зарлаж болно.
- 5.4. ОУУБИС-аас санхүүжүүлэх судалгааны төсөл, тэтгэлгийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг Эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга нар мэргэжлийн шинжээчдээс баг бүрдүүлэн зохион байгуулж, сонгон шалгаруулалтыг явуулна.
- 5.5. Сонгон шалгаруулалтыг 2 долоо хоногийн хугацаанд хийж, шалгарсан төслүүдийн гэрээг 2 дугаар сарын 15-аас 20-ны өдрийн дотор байгуулж, гэрээний хүчинтэй хугацааг санхүүгийн жилээр тооцно.
- 5.6. Шинжээчийн багийн гишүүн судалгааны ажлын төсөл, тэтгэлэгт санал өгсөн тохиолдолд өөрийн оролцоо бүхий төсөл, тэтгэлэгтээ үнэлгээ өгөх эрхгүй болно.
- 5.7. Суурь судалгааны төсөл, профессор, дэд профессорын судалгааны ажлын санхүүжилтийг шинээр эхлэх судалгаанд биш, судалгааны ажлын хүрээнд тодорхой ажил хийгдсэн, анхдагч үр дүн гарсан судалгааны ажлыг дэмжих чиглэлд зарцуулахыг илүүд үзнэ.
- 5.8. Судалгааны ажлын төсөл, тэтгэлгийн удирдагч, гүйцэтгэгчээр жилд нэг төсөлд нэг л удаа оролцоно.

ЗУРГАА. ТӨСЛИЙН ГЭРЭЭ, САНХҮҮЖИЛТ

- 6.1. Судалгааны ажлын төсөл, тэтгэлгийн гэрээг гурван хувь үйлдэн, ОУУБИС-ийн захирал, Эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал, бүрэлдэхүүн сургуулийн захирал, төслийн удирдагч нар гарын үсэг зурж, баталгаажуулна.
- 6.2. Тухайн төслийн гэрээ тусгагдсаны дагуу санхүүжилтийг Санхүүгийн хэлтсээс олгож эхэлнэ.
- 6.3. Судалгааны ажлын төсөл, тэтгэлгийн санхүүжилтийг төсөл хэрэгжүүлэгч этгээдийн данс руу шилжүүлэх бөгөөд төлбөр тооцоо, хяналт үнэлгээ, хэрэгжилтийг ОУУБИС-ийн бүрэлдэхүүн сургуулийн захирал, Эрдэм шинжилгээ хариуцсан нэгж, Захиргаа, хүний нөөцийн алба, Санхүүгийн хэлтсээс хянана.
- 6.4. Төсөл сонгон шалгаруулсан баг төсөл хэрэгжсэнээс хойш 6 сарын дараа судалгааны ажлын явцын тайлантай танилцаж, хугацаандаа хэрэгжиж байгаа төслүүдийн үлдсэн санхүүжилтийг олгох шийдвэрийг Захиргаа, хүний нөөцийн албанаас гаргана.
- 6.5. Санхүүгийн хэлтсээс санхүүжилтийг зориулалтын дагуу ашиглаж буй байдал, худалдан авалт бүрд аудит хийх, санхүүгийн баримт бичгийн бүрдүүлэлт, тайлан, төслийн хүрээнд өр төлбөр үүссэн эсэх, эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжилтийн хувьд эргэн төлөлтийн байдал зэрэгт хяналт тавьж ажиллана.

ДОЛОО. ҮР ДҮНГ ТАЙЛАГНАХ

- 7.1. ОУУБИС-ийн санхүүжилт авсан судалгааны ажлын хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнд аудит хийх, тайлагнах, санхүүгийн тооцоотой холбоотой асуудлыг эрдэм шинжилгээ хариуцсан нэгж, Санхүүгийн хэлтэс, Хяналт үнэлгээний алба, бүрэлдэхүүн сургууль, мэргэжлийн шинжээчидтэй хамтран хариуцна.
- 7.2. Судалгааны ажлын эцсийн тайланг эхлээд тэнхимдээ, дараа нь бүрэлдэхүүн сургуулийн багш нарын хурлаар хэлэлцүүлж, судалгааны болон санхүүгийн тайлан, үр дүнгийн баталгаажилтыг жил бүрийн 3 дугаар сарын 1-ний дотор Эрдэм шинжилгээ хариуцсан нэгж, санхүүгийн хэлтэст ирүүлнэ. Төслийн хэрэгжилтийг шалгасан комисс Захиргааны зөвлөлийн хурлын протокол, үр дүнгийн баталгаажуулалт, тайланг хянан магадалж, төслийг хаана.
- 7.3. Судалгааны ажлын төсөл, тэтгэлгийн удирдагч нь судалгааны гүйцэтгэл ба санхүүгийн зарцуулалтаа сургуулийн Санхүүгийн хэлтэст хүлээлгэн өгнө.
- 7.4. Хүндэтгэх шалтгаанаар үр дүнгээ хугацаандаа тайлагнаагүй, гэрээнд тусгасан ажлын үр дүнг биелүүлээгүй төслийн удирдагч, багш нарын төслийн эцсийн хугацааг төсөл шалгаруулсан ажлын хэсгийн шийдвэрийг үндэслэн 3-12 сараар сунгаж болно.

НАЙМ. ТӨСЛИЙН ҮР ДҮНГ ТҮГЭЭХ

- 8.1. Судалгааны төсөл, тэтгэлэг авсан судалгааны үр дүнгийн тайлан, өгүүлэл, бүтээлийг цаасаар болон цахим байдлаар эрдэм шинжилгээ хариуцсан нэгжид нь хүлээлгэн өгч, мэдээллийг ОУУБИС-ийн эрдэм шинжилгээний мэдээллийн нэгдсэн санд оруулна.
- 8.2. Судалгааны ажлын төсөл, тэтгэлгийн үр дүнг хэвлэн нийтлүүлэх, эрдэм шинжилгээний хуралд илтгэх, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, интернэтээр мэдээлж түгээх, сурталчлахдаа ОУУБИС-ийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн судалгааны ажлын төсөл /тэтгэлэг/-ийн хүрээнд гүйцэтгэсэн болохыг заавал дурдана.

ЕС. ТӨСӨЛД ХАМРАГДАГЧИЙН ХАРИУЦЛАГА

- 9.1. Судалгааны төсөл, тэтгэлэг авсан профессор багш, эрдэм шинжилгээний ажилтнууд нь гэрээнд тусгагдсан судалгааны ажлын үр дүнг бүрэн биелүүлээгүй тохиолдолд санхүүжилтийг гэрээнд заасны дагуу ОУУБИС-д буцаан төлнө.
- 9.2. Судалгааны төсөл, тэтгэлэг авсан профессор багш, эрдэм шинжилгээний ажилтнууд нь судлаачийн ёс зүйг баримтална. Судлаачийн ёс зүйтэй холбоотой үүсэж болзошгүй аливаа асуудлыг төсөл, тэтгэлэгт хамрагдагч өөрөө хариуцна.
- 9.3. Санхүүгийн болон судалгааны тайлангаа хүлээлгэн өгөөгүй профессор, дэд профессор, багш нар болон эрдэм шинжилгээний ажилтнуудад дараагийн 2 жилд судалгааны санхүүжилт олгохгүй.

**ОУУБИС-ИЙН САНХҮҮЖИЛТТЭЙ СУУРЬ СУДАЛГАА, ИННОВАЦИ БОЛОН
ЗАХИАЛГАТ ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТ ХҮСЭГЧИЙН МЭДҮҮЛЭГ**

А.ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	
1	Төсөл (судалгаа)-ийн нэр: Төсөл (судалгаа)-ийн чиглэл: Төслийн дараах чиглэлүүдээс сонгоно уу 1. Суурь судалгаа төсөл 2. Захиалгат төсөл 3. Инновацийн төсөл
2	Бүрэлдэхүүн сургууль, тэнхим:
3	Төсөл (судалгаа)-ийн удирдагчийн цахим хаяг, утасны дугаар:
4	Төсөл (судалгаа)-ийн удирдагч /овог нэр, албан тушаал, цол зэрэг/ Жич: Төслийн удирдагч нь ОУУБИС-ийн үндсэн багш, доктор зэрэгтэй байх
5	Төсөл (судалгаа)-ийн багийн гишүүдийн тоо /төслийн удирдагчаас бусад гишүүдийг бичнэ үү: Нэг. Төслийн багийн нийт багш, үүнээс. 1. Бакалавр зэрэгтэй 2. Магистр зэрэгтэй 3. Доктор зэрэгтэй Жич: “Оюутныг орлоготой байлгахыг дэмжих үүднээс төслийн багт магистрант, докторантын оролцоог хангасан байхыг анхаарна уу.
6	Төсөл (судалгаа)-ийг хэрэгжүүлж эхлэх он, сар, өдөр: Төсөл (судалгаа)-ийг дуусгах он, сар, өдөр: Жич: Төсөл (судалгаа)-ийг хэрэгжих хугацаа 12 сараас хэтрэхгүй байхыг анхаарна уу.
7	Төсөл (судалгаа)-ийг хэрэгжүүлэхэд ОУУБИС-аас хүсэж буй санхүүжилт /төгрөгөөр/:
8	Төсөл (судалгаа)-ийн багийн ажлын байр/ ажлын талбай: /Бүрэлдэхүүн сургууль, судалгааны хүрээлэн ба төв, тэнхим гэх мэт/

9. Төсөл (судалгаа)-ийн багийн гишүүдийн товч мэдээлэл: /Багийн гишүүдийн тооноос хамаарч хүснэгтийг сунгаж болно.

№	Овог, нэр	Хүйс	Регистрийн дугаар	Мэргэжлийн зэрэг: /бакалавр, магистр, доктор/	Холбогдох утас/ цахим хаяг
Нэг. ОУУБИС-ийн багш, судлаач, оюутан					
1					
2					
3					
4					
5					
Хоёр: Түншлэгч байгууллага /Их сургууль, Хүрээлэн, Үйлдвэр, Гарааны компани/ Жич: Энэ хэсэг инновацийн төсөлд хамаарна.					
6					
7					

Б. ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ҮР ДҮН	
10	Төслийн үндэслэл болон өнөөгийн байдал: (Тухайн төслийг хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага, үндэслэл, суурь нөхцөл байдлын талаар бичнэ үү)
11	Төсөл (судалгаа)-ийн зорилго: /Энэ хэсэгт төслийн үндсэн зорилго, гарах өөрчлөлтийн талаар бичнэ. Харин дараагийн хүснэгтэд зорилго тус бүрээр тодруулж бичнэ үү./ Төсөл (судалгаа)-ийн зорилт:
	Үүнд: Хамрах хүрээ, гарах өөрчлөлт /өөрийн төсөл болон судалгааны чиглэлд хамаарах асуудлыг бөглөх/
11.а	Төсөл (судалгаа)-ийг харилцан үр ашигтай хөгжүүлэх, чадавх бэхжүүлэх;

11.б	Туршилт, судалгааны ажилд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх технологийн шинэ, шинэлэг шийдэл дэвшүүлж хэрэгжүүлэх;	
11.в	Сургалт, судалгаа, инновацийн ажлыг шинэ хэлбэрээр үр дүнтэй явуулах;	
11.г	Энтрепренершипыг хөгжүүлэх; /инновацийн төсөлд бичнэ/ Жич: Энтрепренершип гэдэг нь бусдад зориулан үнэт зүйлийг бий болгож, тодорхой хэрэгцээг шийдэх боломж, санааг хэрэгжүүлэх чадамж юм. Энэ үнэт зүйл нь нийгэм, соёл, санхүү, бизнесийн шинж чанартай байж болдог.	

12	Төслөөс гарах үр дүн: (Төсөл (судалгаа)-ийг хэрэгжүүлснээр хүрэх үр дүнгийн төсөөлөл, тухайн үр дүн нь өнөөгийн нөхцөл байдлыг хэрхэн сайжруулах талаар бичнэ үү. үр дүн нь тодорхой, хэмжиглэхүйц, бодитой, тухайн хугацаандаа хэрэгжихүйц байна)		
	Төсөл (судалгаа)-ийн үр дүн:		Үр дүнгийн шалгуур үзүүлэлт
		Төсөл (судалгаа)-ийн эхэнд тооцсон суурь үзүүлэлт	Төсөл (судалгаа)-ийн эцэст гарах үзүүлэлт
	Нэг. ОУУБИС-д		
	Хоёр. Багш судлаачдын хөгжүүлэх хүрээнд:		
13	Үр шим хүртэгчид: (Төсөл хэрэгжсэнээр ОУУБИС ямар үр шим хүртэх талаар бичнэ үү)		
	Үр шим хүртэгч (Зорилтот бүлэг, нийт хүний тоо)	Төслөөс хүртэх үр шим (Үр шим хүртэгчдийн оролцоо, гарах үр дүн)	

В. ТӨСӨЛ (СУДАЛГАА)-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

14. Үйл ажиллагаа болон санхүүгийн төлөвлөгөө: (Төсөл (судалгаа)-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт хийх үед цаг хугацаа, хүн хүч, шаардагдах зардал болон гарах үр дүнг тооцно. Төлөвлөж байгаа үйл ажиллагаанаас хамаарч хүснэгтийг өөрчилж болно.)

Гүйцэтгэх үйл ажиллагаа	Эхлэх, дуусах хугацаа /он, сар/	Гарах үр дүн	Шаардлагатай санхүүжилт /төгрөгөөр
ЭХНИЙ ҮЕ ШАТ /санхүүжилтийн 50% хүртэл/			
Үйл ажиллагаа 1:			
Үйл ажиллагаа 2:			
Үйл ажиллагаа 3:			
.....			
ХОЁР ДАХЬ ҮЕ ШАТ /санхүүжилтийн 50% хүртэл/			
Үйл ажиллагаа 4:			
Үйл ажиллагаа 5:			
Үйл ажиллагаа 6:			

15. Төсөл (судалгаа)-ийн багийн гишүүдийн үүрэг хариуцлага: (Төслийн гишүүн нэг бүрээр бичнэ.)

№	Төсөл (судалгаа)-ийн багийн гишүүний овог нэр:	Гүйцэтгэх ажил, үүрэг
1		
2		
3		
4		
5		

16. Төсөл (судалгаа)-ийн үр дүнг түгээн дэлгэрүүлэх боломж: (ОУУБИС-ийн сургалт болон судалгаа, инновацийг хөгжүүлэх асуудлаар юуны тулд, хэн, хэрхэн түгээн дэлгэрүүлэх тухай)

17. Эрсдэл, шийдвэрлэх арга зам: (Төсөл (судалгаа)-ийг амжилттай хэрэгжүүлэхэд тодорхой эрсдэлүүд байвал бичнэ үү.)

18 Төсөл (судалгаа)-ийн тогтвортой байдал, үр нөлөө: (Төсөл (судалгаа) хэрэгжиж дууссаны дараа тухайн төсөл (судалгаа)-ийн хүрээнд хэрэгжүүлж эхэлсэн үйл ажиллагааг цааш үргэлжлүүлж, сайжруулах, эсвэл тогтвортой байдлыг хангах асуудлаар урьдчилан шинжилгээ хийсэн бол бичнэ үү.)

Төсөл (судалгаа)-ийн удирдагч:
овогтой /...../ регистрийн дугаартай миний
бие ОУУБИС-ийн санхүүжилттэй судалгааны ажлын төслийн мэдүүлгийг үнэн зөв,
бүрэн бичсэн болохыг үүгээр баталж байна.
Төсөл (судалгаа)-ийн удирдагч: /Гарын үсэг/

**ПРОФЕССОР, ДЭД ПРОФЕССОР, ДОКТОР БАГШ НАРТ ОЛГОХ
СУДАЛГААНЫ ТӨСӨЛ ХҮСЭГЧИЙН МЭДҮҮЛЭГ**

А. СУДАЛГААНЫ АЖЛЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	
1	Судалгааны ажлын нэр: Судалгааны ажлын чиглэл:
2	Бүрэлдэхүүн сургууль, тэнхим, нэгж:
3	Тэтгэлэг мэдүүлэгчийн цахим хаяг, утасны дугаар:
4	Тэтгэлэг мэдүүлэгч (овог, нэр, албан тушаал, цол зэрэг):
5	Судалгааны ажил эхлэх он, сар, өдөр: Судалгааны ажил дуусах он, сар, өдөр: Жич: Төсөл хэрэгжих хугацаа 12 сараас хэтрэхгүй байхыг анхаарна уу.
6	Судалгааны ажлыг гүйцэтгэхэд ОУУБИС-аас хүсэж буй санхүүжилтийн хэмжээ (төгрөгөөр):

Б. СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО, ҮР ДҮН		
1	Судалгааны ажлын үндэслэл болон өнөөгийн байдал: (Тухайн судалгааны ажлыг хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага, үндэслэл, суурь нөхцөл байдлын талаар бичнэ үү)	
2	Судалгааны ажлын зорилго: (Энэ хэсэгт үндсэн зорилго, гарах өөрчлөлтийн талаар бичнэ.) Судалгааны ажлын зорилт:	
3	Судалгааны ажлаас гарах үр дүн: (Хүрэх үр дүнгийн төсөөлөл, тухайн үр дүн нь судалгааны тэргүүлэх болон хавсарга судалгааны чиглэлийг хэрхэн сайжруулах талаар бичнэ үү.)	
	Үр дүн:	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт
		Судалгааны ажлын эхэнд тооцсон суурь үзүүлэлт
		Судалгааны ажлын эцэст гарах үзүүлэлт
4	Судалгааны ажлын ач холбогдол:	

5 Судалгааны ажилд саад болж болзошгүй эрсдэл, хүчин зүйлс:

В. СУДАЛГААНЫ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Үйл ажиллагаа болон санхүүгийн төлөвлөгөө: (Судалгааны ажлаа төлөвлөхдөө үргэлжлэх цаг хугацаа, шаардлагатай хүн хүч, зардал болон гарах үр дүнг тооцно. Төлөвлөж байгаа үйл ажиллагаанаас хамаарч хүснэгтийг өөрчилж болно.)

Гүйцэтгэх үйл ажиллагаа	Эхлэх, дуусах хугацаа /он, сар/	Гарах үр дүн	Гарах зардал (100%-н санхүүжилтийг тусгах)
Үйл ажиллагаа 1:			
Үйл ажиллагаа 2:			
Үйл ажиллагаа 3:			

Тэтгэлэг хүсэгч: овогтой
/...../ регистрийн дугаартай миний бие судалгааны ажлын мэдүүлгийг үнэн зөв, бүрэн бичсэн болохыг үүгээр баталж байна.

Судалгааны ажлыг тэтгэлэг хүсэгч: /Гарын үсэг/
Огноо

**ОУУБИС-ИЙН САНХҮҮЖИЛТТЭЙ ЗАЛУУ СУДЛААЧДЫН
БАГИЙН ТЭТГЭЛЭГ ХҮСЭГЧИЙН МЭДҮҮЛЭГ**

А. СУДАЛГААНЫ АЖЛЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	
1	Судалгааны ажлын нэр: Судалгааны ажлын чиглэл:
2	Бүрэлдэхүүн сургууль, тэнхим, нэгж:
3	Тэтгэлэг мэдүүлэгчийн цахим хаяг, утасны дугаар:
4	Тэтгэлэг мэдүүлэгч (овог, нэр, албан тушаал, цолл зэрэг):
5	Тэтгэлэг мэдүүлэгчийн төрсөн он сар өдөр:
6	Судалгааг хэрэгжүүлж эхлэх он, сар, өдөр: Судалгааг дуусах он, сар, өдөр: Жич: Судалгааг хэрэгжүүлэх хугацаа 12 сараас хэтрэхгүй байхыг анхаарна уу.
7	Судалгааны ажлыг гүйцэтгэхэд ОУУБИС-аас хүсэж буй санхүүжилтийн хэмжээ (төгрөгөөр):

Б. СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО, ҮР ДҮН	
1	Судалгааны ажлын үндэслэл болон өнөөгийн байдал: (Тухайн судалгааны ажлыг үргэлжлүүлэх хэрэгцээ шаардлага, үндэслэл)
2	Судалгааны ажлын зорилго: (Энэ хэсэгт үндсэн зорилго, гарах өөрчлөлтийн талаар бичнэ.) Судалгааны ажлын зорилт:
3	Судалгааны ажлаас гарах үр дүн: (Хүрэх үр дүнгийн төсөөлөл, тухайн үр дүн нь докторын дипломын ажлын үр дүнг хэрхэн сайжруулах талаар бичнэ үү.)
4	Судалгааны ажлын ач холбогдол:
5	Судалгааны ажилд саад болж болзошгүй эрсдэл, хүчин зүйлс:

В. ХАМТРАН АЖИЛЛАХ СУДЛААЧДЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ				
№	Овог, нэр	Зэрэг: /доктор/мастер/бакалавр/	Ажлын туршлага	Холбогдох утас/ цахим хаяг
Нэг. ОУУБИС-ийн багш, судлаач, оюутнууд:				
1				
2				
3				
4				
Хоёр. Түншлэгч байгууллага				
5				

6				
7				

Г. СУДАЛГААНЫ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагаа болон санхүүгийн төлөвлөгөө: (Судалгааны ажлаа төлөвлөхдөө үргэлжлэх цаг хугацаа, шаардлагатай хүн хүч, зардал болон гарах үр дүнг тооцно. Төлөвлөж байгаа үйл ажиллагаанаас хамаарч хүснэгтийг өөрчилж болно.)

Гүйцэтгэх үйл ажиллагаа	Эхлэх хугацаа (он, сар)	Дуусах хугацаа (он, сар)	Гарах үр дүн	Гарах зардал (100%-н санхүүжилтийг тусгах)
Үйл ажиллагаа 1:				
Үйл ажиллагаа 2:				
Үйл ажиллагаа 3:				

Тэтгэлэг хүсэгч: овогтой
 /...../ регистрийн дугаартай миний бие судалгааны ажлын мэдүүлгийг үнэн зөв, бүрэн бичсэн болохыг үүгээр баталж байна.
 Судалгааны ажлыг тэтгэлэг хүсэгч: /Гарын үсэг/
 Огноо

ӨРТӨГ ХУВААЛЦАХ ХАМТАРСАН ТӨСӨЛ ХҮСЭГЧИЙН МЭДҮҮЛЭГ

А. СУДАЛГААНЫ АЖЛЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	
1	Судалгааны ажлын нэр: Судалгааны ажлын чиглэл:
2	Бүрэлдэхүүн сургууль, тэнхим, нэгж:
3	Төслийн удирдагчийн цахим хаяг, утасны дугаар:
4	Төслийн удирдагч (овог, нэр, албан тушаал, цол зэрэг):
5	Хамтрагч байгууллагын нэр, цахим хаяг, утасны дугаар:
6	Хамтрагч байгууллагын сонирхлоо илэрхийлсэн байдал (төсөлд хамтран оролцох, хамтран гүйцэтгэх сонирхлоо илэрхийлсэн захидал, нотлох баримтыг хавсаргана):
7	Судалгааг хэрэгжүүлж эхлэх он, сар, өдөр: Дуусгах он, сар, өдөр: Жич: Төслийг хэрэгжүүлэх хугацаа 12 сараас хэтрэхгүй байхыг анхаарна уу.
8	Судалгааны ажлыг гүйцэтгэхэд ОУУБИС-аас хүсэж буй санхүүжилтийн хэмжээ (төгрөгөөр):
9	Судалгааны ажлыг гүйцэтгэхэд хамтрагч байгууллагын санхүүжилтийн хэмжээ (төгрөгөөр):
10	Хамтарсан төсөлд оролцогчдын мэдээлэл (нэрс, эрдмийн зэрэг, цол, төсөлд ажиллаж байсан туршлага, бүтээлийн жагсаалт, гүйцэтгэх үүрэг хариуцлага):

Б. ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ҮР ДҮН

1	Төслийн үндэслэл, шаардлага, ач холбогдол: Төслийн зорилго: (Энэ хэсэгт үндсэн зорилго, гарах өөрчлөлтийн талаар бичнэ.)
2	Судалгааны ажлын зорилтууд:
3	Төслөөс гарах үр дүн:
4	Төслийн үр ашиг:
5	Төсөлд саад болж болзошгүй эрсдэл, хүчин зүйлс:

В. ТӨСЛИЙН КАЛЕНДАРЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагаа болон санхүүгийн төлөвлөгөө: (Судалгааны ажлаа төлөвлөхдөө үргэлжлэх цаг хугацаа, шаардлагатай хүн хүч, зардал болон гарах үр дүнг тооцно. Төлөвлөж байгаа үйл ажиллагаанаас хамаарч хүснэгтийг өөрчилж болно.)

Гүйцэтгэх үйл ажиллагаа	Эхлэх, дуусах хугацаа /он, сар/	Гарах үр дүн	Гарах зардал (100%-н санхүүжилтийг тусгах)
Үйл ажиллагаа 1:			
Үйл ажиллагаа 2:			
Үйл ажиллагаа 3:			

Төслийн удирдагч: овогтой
 /...../ регистрийн дугаартай миний бие судалгааны ажлын мэдүүлгийг үнэн зөв, бүрэн бичсэн болохыг үүгээр баталж байна.
 Төслийн удирдагч: /Гарын үсэг/
 Огноо

**НОМ, СУРАХ БИЧИГ, ГАРЫН АВЛАГА ХЭВҮҮЛЭХ
ТЭТГЭЛЭГ ХҮСЭГЧИЙН МЭДҮҮЛЭГ**

А. СУДАЛГААНЫ АЖЛЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	
1	Ном, сурах бичиг, гарын авлагын нэр:
2	Бүрэлдэхүүн сургууль, тэнхим, нэгж:
3	Тэтгэлэг мэдүүлэгчийн овог, нэр, албан тушаал, цол зэрэг:
4	Тэтгэлэг мэдүүлэгч ОУУБИС-ийн үндсэн багшийн цахим хаяг, утасны дугаар:
6	Хамтран зохиогчийн овог, нэр, албан тушаал, цол зэрэг:
7	Хамтран зохиогчийн цахим хаяг, утасны дугаар:
8	Тэтгэлгийг авч эхлэх он, сар, өдөр: Тэтгэлгийг төлж дуусах он, сар, өдөр: Жич: Тэтгэлгийг эргэн төлөх хугацаа 10 сараас хэтрэхгүйг анхаарна уу.
9	ОУУБИС-аас хүсэж буй санхүүжилтийн хэмжээ (төгрөгөөр):

Б. СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО, ҮР ДҮН	
1	Сурах бичиг, гарын авлага нь боловсрол эзэмших тэгш байдлыг хангасан, хөтөлбөрийн онцлогийг хэрхэн тусгасан байдал:
2	Сурах бичиг нь боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр дэх хичээлийн агуулгад хэрхэн нийцсэн байдал:
3	Ном, сурах бичиг, гарын авлагад олон улсын болон Монгол улсын индекс (ISBN)-ийн дугаар:
4	Ном, сурах бичиг, гарын авлага нь зохиогчийн эрхийг зөрчөөгүй эсэх: (Зохиогчийн эрхийн гэрчилгээ авсан бол хавсаргах)
5	Суралцагчид уг сурах бичиг, ном, гарын авлагыг бие даан судалж, мэдлэг, чадварыг эзэмших, практикт хэрэглэх боломжтой эсэх:
6	Хэл найруулга, зөв бичгийн дүрмийн хувьд алдаагүй, зөв оновчтой, товч тодорхой, энгийн ойлгомжтой, эмх цэгцтэй болсон эсэх:

В. ТЭТГЭЛГИЙН САНХҮҮЖИЛТИЙГ ЭРГЭН ТӨЛӨХ ГРАФИК

Үүнийг санхүүгийн хэлтэстэй тохирон хийж, графикийг хавсаргах

Г. Үйл ажиллагаа болон санхүүгийн төлөвлөгөө: (Ном, сурах бичиг, гарын авлага хэвлүүлэхээр төлөвлөхдөө үргэлжлэх цаг хугацаа, зардал болон гарах үр дүнг тооцно. Төлөвлөж байгаа үйл ажиллагаанаас хамаарч хүснэгтийг өөрчилж болно.)

Гүйцэтгэх үйл ажиллагаа	Эхлэх, дуусах хугацаа /он, сар/	Гарах үр дүн	Гарах зардал (100%-н санхүүжилтийг тусгах)
Үйл ажиллагаа 1:			
Үйл ажиллагаа 2:			
Үйл ажиллагаа 3:			

Тэтгэлэг хүсэгч: овогтой
/...../ регистрийн дугаартай миний бие судалгааны ажлын мэдүүлгийг үнэн зөв, бүрэн бичсэн болохыг үүгээр баталж байна.

Судалгааны ажлыг тэтгэлэг хүсэгч: /Гарын үсэг/

Огноо